

2026 оны ... дугаар сарын ...-ны өдөр

**ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД  
ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН  
ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН  
ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага**

**1.1.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл**


Одоо хэрэгжиж буй Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль(Цаашид “ИХШХШтХ” гэх) анх 2002 онд батлагдсанаас хойш нийт 37 удаагийн нэмэлт өөрчлөлт орсон хэдий ч тогтвортой үйлчилж буй хууль юм. ИХШХШтХ нь нийгмийн харилцааг зохицуулдаг суурь хууль болохын хувьд тогтвортой үйлчлэх шаардлагатай хэдий ч манай орны эдийн засгийн өсөлт, нийгмийн харилцааны хөгжлөөс үүдэн хэрэг маргааны тоо өссөн, орчин үеийн мэдээллийн технологийн ололт амжилтыг шүүн таслах ажиллагаанд нэвтрүүлэх шаардлагатай болсон зэргээс тус хуулийг шинэчлэн найруулах шаардлага үүсээд байна.

Энэ хүрээнд Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.2.7-д Иргэний хэрэг хянан шийдвэрлэх, иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэл, компани, шударга өрсөлдөөн, монопол, хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгоно, тус хөтөлбөрийн 4.1.5.3-т Шүүхийн процессыг цахимжуулж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцыг ил тод болгож, хэрэг, маргааныг шуурхай, үр дүнтэй шийдвэрлэнэ гэж тус тус заажээ.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн 37-д Шүүх хуралдааны өмнөх шатанд шүүхийн урьдчилан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой зохицуулалтыг нарийвчлах, оновчтой механизмыг бүрдүүлэх, үндэслэл, журмыг тодорхойлох, арилжаа эрхлэгчид хоорондын маргаан шийдвэрлэх, хэрэг хянан шийдвэрлэх процессыг хөнгөвчлөх, олон улсын чиг хандлагад нийцүүлэн цахим орчинд хийгдсэн гэрээ, хэлцлийг шүүхэд нотлох баримтаар тооцох эрх зүйн орчныг бүрдүүлэх, иргэн болон захиргааны хэргийн шүүхийн хэрэг, маргааны харьяаллын давхардлыг арилгах, иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын хооронд үүссэн иргэний эрх зүйн маргааныг шүүх хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг сайжруулж, боловсронгуй болгох үүднээс ИХШХШтХ-г шинэчлэн найруулахаар тусгажээ.

Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлөөс эрхлэн гаргадаг “Шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээ”-нээс анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэгдсэн хэрэгт иргэний хэргийн эзлэх хувь хэмжээг сүүлийн 5 жил болох 2021-2025 оны хооронд авч үзэл тогтмол 60 орчим хувийг эзэлж байна.

ИХШХШТХ нь манай улсын шүүн таслах ажиллагаанд эзлэх хувь хэмжээ их бөгөөд тус хуулийг шинэчлэн найруулснаар хүний эрхийг хангах, шударга ёсны тогтолцоо төлөвшихөд ахиц дэвшил авч ирнэ.



ИХШХШТХ-ийг шинэчлэн найруулах гол үндэслэл нь манай улсын иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа удаашралтай байгаатай холбоотой юм.

## 1.2.Хуулийн төсөл боловсруулах шаардлага, үзэл баримтлал

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааг хурдан шуурхай, үр дүнтэй явуулах эрх зүйн орчныг бий болгох үндэс нь нэг талаас шүүх ХХША-г хурдан шуурхай, үр дүнтэй удирдан явуулах, нөгөө талаас хэргийн оролцогч ХХША-д үнэнч шударгаар оролцох нөхцөлийг хангах юм.



### **1.2.1.Шүүх ХХША-г хурдан шуурхай, үр дүнтэй удирдан явуулах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох**

❖ Нэхэмжлэл тодорхой бус байгаа тул нэхэмжлэлийн шаардлага, үндэслэлийг тодруулах ажиллагааг боловсронгуй болгох;

❖ Нэхэмжлэлийн зүйлийг хэрэг үүсгэх шүүгчийн захирамжид тодорхой тусгадаг байх;

❖ Урьдчилсан хуралдааныг бий болгох:

▪ Хэргийн оролцогчийн шаардлага ба татгалзлын үндэслэлийн хүрээнд маргаантай болон маргаангүй үйл баримтыг тодорхойлох;

▪ Хэргийн маргаантай үйл баримтын хүрээнд нотлох баримт гаргах, цуглуулах, бүрдүүлэх талаар тайлбарлах;

▪ Хэргийн оролцогчоос гаргасан нотлох баримт бүрдүүлэх тухай хүсэлт шийдвэрлэх, нотлох баримт бүрдүүлэх захирамжийн биелэлтийг хангах.

❖ Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх захирамжид хэргийн маргаантай болон маргаангүй үйл баримтыг тодорхой тусгадаг байх;

❖ Шүүх хуралдааныг хэргийн маргаантай үйл баримтад төвлөрч нотлох баримтыг шинжлэн судлах байдлаар явуулах зохицуулалт бий болгох;

❖ Хэрэг хянан шийдвэр ажиллагааны үр дүнтэй байдлыг хангах зорилгоор нотариатын мэдэгдэх хуудас, төлбөр гаргуулах ажиллагааны зохицуулалтыг боловсронгуй болгох;

❖ Хэрэг хянан шийдвэр ажиллагааны явцад мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэх, зохицуулалтыг сайжруулах.

### **1.2.2.Хэргийн оролцогч ХХША-д үнэнч шударгаар оролцох эрх зүйн зохицуулалтыг бий болгох**

❖ Хэргийн оролцогчийн эрх зүйн байдлыг тодорхой болгох:

▪ Бие даасан шаардлага гаргасан гуравдагч этгээд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох;

▪ Бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох;

▪ Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамтран оролцох хэлбэрийг тодорхой болгох;

▪ Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх, үүрэг залгамжлан оролцох журмыг тодорхой болгох.

❖ Хариуцагчийн хаяг тодруулах, нэхэмжлэл гардуулах ажиллагааг боловсронгуй болгох, хариуцагч хариу тайлбар ирүүлээгүй тохиолдолд үүсэх үр дагаврыг тодорхой болгох;

❖ Хэргийн оролцогч хууль зүйн туслалцаа авах эрхээ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад болохооргүй байдлаар хэрэгжүүлдэг байх;

❖ Хэргийн оролцогч хүсэлт, тайлбар, нотлох баримтаа шүүхэд гаргах боломжтой үедээ хугацаа алдалгүйгээр гаргадаг байх, урьд нь гаргах бололцоотой байсан боловч шүүх хуралдааны үед гаргасан нь хүндэтгэн үзэх шалтгаангүй бол шүүх тэдгээрийг хүлээн авахаас татгалздаг байх;

❖ Хэрэг хянан шийдвэрлэх тодорхой ажиллагааны зардлыг ажиллагаа явуулах хүсэлт гаргасан этгээдээр урьдчилан төлүүлдэг байх;

❖ Хэргийн оролцогч шүүгчийг татгалзан гарах үндэслэл, үе шатыг тодорхой болгох.

### **1.3.Практик шаардлага**

2002 оноос хойш ИХШХШТХ-г хэрэгжүүлэх хугацаанд УДШ-ээс шүүхийн практикийг нэг мөр болгох зорилгоор тайлбар, зөвлөмж зэргийг гаргаж, шүүхийн практик тогтоход нөлөө үзүүлж ирсэн. Гэвч эдгээр баримт бичиг нь хуулийн албан ёсны эх сурвалж биш бөгөөд шүүхийн практикт тогтсон зарим ойлголт нь хуульд тусгагдаагүй хэвээр байна.

Иймээс УДШ-ийн тайлбар, зөвлөмж болон олон жилийн турш тогтвортой хэрэглэгдэж ирсэн шүүхийн сайн практикыг хуульд тусгана. Мөн шүүхийн практикт харилцан адилгүй байдлаар ИХШХШТХ-г хэрэглэх нөхцөлийг бууруулах зорилгоор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарим зохицуулалтыг илүү тодорхой болгоно. Үүнд:

– Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой баримт бичгийг хүргүүлэх зохицуулалтыг боловсронгуй болгох;

– Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой хүсэлт шийдвэрлэх ажиллагааны зохицуулалтыг боловсронгуй болгох;

– Шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх ажиллагааг боловсронгуй болгох;

– Хэрэг шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх, хэрэг нэгтгэх, тусгаарлах ажиллагааны зохицуулалтыг тодорхой болгох;



– Шүүх бүрэлдэхүүний талаарх зохицуулалтыг тодорхой болгох;

– Хэргийн болон шүүхийн харьяаллын талаарх зохицуулалтыг тодорхой болгох;

– Нотлох баримт гаргах, цуглуулах, бүрдүүлэх ажиллагааг боловсронгуй болгох;

– Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зохицуулалтыг боловсронгуй болгох.

Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлөөс гаргасан “Шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээ”-нээс авч үзвэл сүүлийн 5 жилийн хугацаанд авч үзэхэд анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн иргэний хэргийн тоо 2021 онд 45444 хэрэг байсан бол, 2025 онд 95408 хэрэг болж даруй 2 дахин өссөн байна.



Ийнхүү иргэний шүүхээр хянан шийдвэрлэгдэх хэргийн тоо огцом өсөж байгаа улмаас иргэний шүүхийн нөөцийг зөв хуваарилах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг илүү дүнтэй удирдан явуулах шаардлага бий болжээ.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хэргийг нэг талаас хурдан, шуурхай шийдвэрлэдэг байх, нөгөө талаас үнэн зөвөөр шийдвэрлэдэг байх ёстой бөгөөд энэ хоёр хүчин зүйлийн тэнцвэрийг зохистой хангасан хуулийг байх ёстой иргэний процесс хууль гэж үздэг.

Иймээс манай улсын иргэний шүүхийн нөөц бололцоонд тохирсон хэргийг үнэн зөв, хурдан шуурхай шийдвэрлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор ИХШХШТХ-г шинэчлэн найруулах шаардлагатай.

### **Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулах харилцаа, хамрах хүрээ, агуулгад өөрчлөлт гарч, нийт заалтын тавиас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орж байгаа тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1 дэх заалтын дагуу хуулийн төслийг шинэчилсэн найруулгын хэлбэрээр боловсруулна.

#### **Хуулийн төслийн зорилго**

Монгол Улсын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 1 дэх хэсгийн 14-т “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй” гэж заасны дагуу иргэний шүүхээр хамгаалуулах үндсэн эрхийг хангах зорилго бүхий хууль нь ИХШХШТХ юм.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь дараах 11 хэсгээс бүрдэнэ.

<b>№</b>	<b>АГУУЛГА</b>
1	I ХЭСЭГ.ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЕРӨНХИЙ ҮНДЭСЛЭЛ
2	II ХЭСЭГ.ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ НИЙТЛЭГ ЖУРАМ
3	III ХЭСЭГ.ИРГЭНИЙ ХЭРГИЙГ АНХАН ШАТНЫ ШҮҮХЭЭР ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ
4	IV ХЭСЭГ.ИРГЭНИЙ ХЭРГИЙГ АНХАН ШАТНЫ ШҮҮХЭЭР ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУСГАЙ ЖУРАМ
5	V ХЭСЭГ.ИРГЭНИЙ ХЭРГИЙГ АНХАН ШАТНЫ ШҮҮХЭЭР ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ОНЦГОЙ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ
6	VI ХЭСЭГ.ИРГЭНИЙ ХЭРГИЙГ ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХЭЭР ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ

7	VII ХЭСЭГ.ИРГЭНИЙ ХЭРГИЙГ ХЯНАЛТЫН ШАТНЫ ШҮҮХЭЭР ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ
8	VIII ХЭСЭГ.ШИНЭЭР ИЛЭРСЭН НӨХЦӨЛ БАЙДЛЫН УЛМААС ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ ХЯНАХ ЖУРАМ
9	IX ХЭСЭГ.АРБИТРЫН АЖИЛЛАГААНД ШҮҮХ ОРОЛЦОХ ЖУРАМ
10	X ХЭСЭГ.ОЛОН УЛСЫН ХУВИЙН ЭРХ ЗҮЙН ХОЛБОГДОЛТОЙ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ
11	XI ХЭСЭГ.ИРГЭНИЙ ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЖУРАМ

**Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа үр нөлөөтэй, хурдан шуурхай явагдах эрх зүйн орчин бүрднэ.

Шүүгч, шүүх бүрэлдэхүүний зүгээс хэргийн онцлогтой нийцүүлж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удирдан явуулах боломжтой болно.

Хэргийн оролцогч мэтгэлцэх зарчмын хүрээнд олгогдож буй эрх үр дүнтэй хэрэгжүүлэх боломжоор хангагдана.

**Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн талаар**

Энэ хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хууль тогтоомжтой нийцсэн байна.

Иргэний хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийг тус тус боловсруулна.

-----oOo-----

